

Нийцлийн аудитын тайлан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт



**ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ХОЛБОГДОХ
БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНУУД БҮРЭН
ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА**

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга бөгөөд тэргүүлэх аудитор М.Хуанган</p> <p>Аудитын менежер Х.Женисбек</p> <p>Аудитын баг:</p> <p>Аудитор Ж.Назгүл</p> <p>Аудитор Р.Баярмаа</p> <p>2018 оны 11 дүгээр сар</p> <p>Аудитын тайланг www.audit.mn вэб сайтаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 99668909, 99265539 дугаарын утсаар харилцана уу</p> <p>ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр, 1 дүгээр давхар 102, 104, 217 тоот өрөө</p>	<p>Товчилсон үгийн тайлбар 3</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4-6</p> <p>Бүлэг А. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдсан боловч зарим байгууллагууд мэдээллийг бүрэн оруулаагүй байна 7-15</p> <p>A.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тогтмол мэдээлэх мэдээллийг 34 хувь нь, долоон хоногийн дотор мэдээлэх мэдээллийг 14.4 хувь нь мэдээлээгүй байна. 7-14</p> <p>A.2. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлсэн байна..... 14-15</p> <p>Бүлэг Б. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна 16-18</p> <p>B.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах 3897.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59 тендерт шалгарсан 49 аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг олон нийтэд мэдээлээгүй зөрчил илэрсэн нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна..... 16-17</p> <p>B.3 Төрийн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа хувийн 13 ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цэс нээгээгүй, санхүүжилтийг бүрэн мэдээлээгүй байна. 17-18</p> <p>В. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна..... 20-25</p> <p>V.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд аймгийн ИТХ-аас хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна..... 19-20</p> <p>V.2 Шилэн дансны үйл ажиллагаанд Төсвийн ерөнхий захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна. 20-22</p> <p>V.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэлтэй иргэд олон нийт төдийлөн ач холбогдол өгч танилцаж, сонирхдоггүй байна..... 22-23</p> <p>V.4 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын дагуу шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоодын хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцоогүй байна..... 23-24</p> <p>Дүгнэлт 25</p> <p>Зөвлөмж 26</p> <p>Тайлангийн хавсралт 27-29</p> <p>Холбогдох байгууллагын санал 30</p> <p>Гарын үсэг 31</p>
---	---

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн Төвлөрүүлэн захирагч
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХҮГазар	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЦШСГ	Цахилгаан шугам сүлжээний газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх, аудитын зорилт:

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 03 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5, 3.1.6-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх
- Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх

Тус аудитын асуудлын шинжилгээнд орсон орон нутагт хамааралгүй 1 дүгээр бүлгийн А.3, 2 дугаар бүлгийн Б.1 дэх асуудлуудыг тайланд тусгаагүй болно.

2. Хамарсан хүрээ:

Энэхүү аудитад аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу хамрагдвал зохих нийт 208 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс 73 этгээдэд итгэл үзүүлж, 145 байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллийг шалгав.

Мөн улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа 60 аж, ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 14 байгууллагыг хамруулав.

3. Үндсэн мэдээлэл:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагууд нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 7, 3.1.2-т заасан төрийн өмчит үйлдвэрийн газар 7, 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 3 төрлийн мэдээллийг оруулахаар хуульчилсан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 онд хийсэн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагч 1, төсвийн төвлөрүүлэн захирагч 14, орон нутгийн төсвийн байгууллага 126, улсын төсвийн байгууллага 26, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 7 нийтдээ 174 байгууллагын шилэн дансны үйл ажиллагаанд аудит хийж, 43675.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 25 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага тус тус өгөгдсөн байна.

4. Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлэв.

5. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллийг дансны хуулга, анхан шатны баримт, журналтай тулгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, судалгаа авах, дүн шинжилгээ хийх, газар дээр нь биет ажиглалт хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

6. Аудит хийхэд ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

7. Гүйцэтгэх хугацаа:

Аудитын талбарын ажлыг 2018 оны 11 дугаар сарын 05-наас, тайлагналын үе шатыг 11 дүгээр сарын 23-нд эхэлж 11 дүгээр сарын 28-нд дуусгасан болно.

8. Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аудитор Ж.Назгүл ахалж, аудитор Р.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлж, аудитын тайланг бэлтгэв.

Бүлэг 1

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдсан боловч зарим байгууллагууд мэдээллийг бүрэн оруулаагүй байна.

Ерөнхий зүйл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн нийцлийн аудитад төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани нийт 145 байгууллагын шилэн дансны үйл ажиллагааг хамруулав.

Аудитын төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, дэд зорилтуудын дагуу Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, тэдгээр нь хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэхийг асуудлын шинжилгээний асуултын дагуу тулган шалгав.

Энэхүү аудитаар төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагааг шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон байгууллагын өөрийн цахим хуудсанд тавьсан мэдээллийг шалгаж баталгаажуулсан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгах аудитын төлөвлөгөөний хүрээнд аймгийн зарим төсөвт байгууллагуудын мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулсан мэдээллүүд нь холбогдох хууль, журмын дагуу үнэн зөв хөтлөгдсөн эсэхийг газар дээр нь шалгаж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, засаж залруулах, зөвлөгөө өгөх хэлбэрээр нийцлийн аудитыг хэрэгжүүллээ.

А. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдсан боловч зарим байгууллагууд мэдээллийг бүрэн оруулаагүй байна.

А.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тогтмол мэдээлэх мэдээллийг 34 хувь нь, долоо хоногийн дотор мэдээлэх мэдээллийг 14.4 хувь нь мэдээлээгүй байна.

Баян-Өлгий аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дүгээр заалтад хамаарах 208 байгууллагыг энэ удаагийн аудитад хамруулж шалгав. Үүнийг хүснэгтээр нэгтгэж харуулбал:

Хүснэгт №1

Хуулийн заалт	Орон нутгийн төсөвт байгууллага		Улсын төсөвт байгууллага		ОНӨААТҮГ	Нөхөрлөл	ААНБ	Нийт
	ТЭЗ	ТШЗ	ТШЗ	ЗГТС				
3.1.1 ¹	15	107	18	3	2			145
3.1.2 ²								0
3.1.3 ³								0
3.1.4 ⁴		2				2	45	49
3.1.5 ⁵							14	14
Нийт	15	109	18	3	2	2	59	208

Эх сурвалж: Аудитад хамрагдах байгууллагын судалгаа

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 145, 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 1 байгууллага, нийт 146 байгууллага шилэн дансны цахим хуудсанд бүртгэлтэй байна.

Харин хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа 45 аж ахуйн нэгж, 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 13 байгууллага, нийт 58 байгууллага нэгдсэн цахим хуудаст бүртгэгдээгүй, цэс нээлгээгүй байна.

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино гэж уг хуулийн зорилтыг тодорхойлсон байдаг.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасны дагуу тогтмол мэдээлэх мэдээллийг байгууллагуудын мэдээлсэн байдлыг нэгтгэж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №2

№	Тогтмол мэдээлэх мэдээлэл	Нийт мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Мэдээлээгүй	Хугацаа хоцорч мэдээлсэн
1	6.1.1 Тухайн жилийн төсөв	131	91	25	15
2	6.1.1. ОНХС-ийн төлөвлөгөө	15	11	3	1

3	6.1.1. ХАА-ны төлөвлөгөө	15	6	9	0
4	6.1.2. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл	128	103	21	4
5	6.1.2.Өмнөх оны төсвийн гүйцэтгэл	128	101	25	2
6	6.1.3. Дараа жилийн төсвийн төсөл	144	74	51	19
7	6.1.4. Хагас жилийн санхүүгийн тайлан	144	93	35	16
8	6.1.4. Жилийн эцсийн санхүүгийн тайлан	144	99	40	5
9	6.1.5. ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт	144	95	46	3
10	6.1.5. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	58	10	47	1
11	6.1.6. Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	130	97	33	0
	Нийт	1181	780	335	66

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас авч нэгтгэсэн судалгаа

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан тухайн жилийн төсвийг мэдээлэх ёстой 131 байгууллагаас 91 байгууллага буюу 69.4 хувь нь, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг мэдээлэх ёстой 15 Засаг даргаас 11 буюу 73 хувь нь, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээлэх ёстой 15 Засаг даргаас 6 буюу 40 хувь нь хуулийн хугацаандаа мэдээлсэн байна.

Харин тухайн жилийн төсвийг 25 байгууллага буюу 19.1 хувь нь мэдээлээгүй, 15 байгууллага буюу 11.4 хувь нь хугацаа хоцроож мэдээлдсэн, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг Булган, Баяннуур, Ногооннуур сумын Засаг дарга нар мэдээлээгүй, Бугат сумын Засаг дарга хугацаа хоцроож мэдээлсэн бол Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 9 сумын Засаг дарга мэдээлээгүй нь хуулийн 6.1.1-т заасныг зөрчисөн байна.

- Өмнөх оны болон хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг мэдээлэх ёстой 128 байгууллагаас 103 байгууллага буюу 80.4 хувь нь хагас жилийн, 101 байгууллага буюу 79 хувь нь өмнөх оны гүйцэтгэлийг мэдээлж, 4 байгууллага хагас жилийн, 2 байгууллага өмнөх оны төсвийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлжээ.

Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг улсын төсвийн 3, орон нутгийн төсвийн 18 байгууллага, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг улсын төсвийн 4, орон нутгийн төсвийн 21 байгууллага мэдээлээгүй байна.

2017 оны сүүлийн 3 сар, 2018 оны эхний 9 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг давхардсан тоогоор 1536 байгууллага мэдээлэх ёстойгоос 1155 байгууллага хугацаандаа мэдээлсэн байна. Харин 200 байгууллага төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 181 байгууллага шилэн дансны цэсдээ мэдээлээгүй байна. Энэ нь хуулийн 6.1.2-т заасан “Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны

төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 8-ны дотор мэдээлнэ” гэж заасныг тус тус зөрчжээ.

- Дараа жилийн төсвийн төслийг шилэн дансны цахим хуудаст мэдээлэх 144 байгууллагаас 74 байгууллага буюу 51.4 хувь нь хуулийн хугацаандаа мэдээлж, хуулийн 6.1.3-д “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор” гэж заасныг зөрчисөн, 19 байгууллага буюу 13.2 хувь нь хугацаа хоцроож мэдээлж, 51 байгууллага буюу 35.4 хувь нь уг мэдээллийг оруулаагүй байна.

- Хуулийн 6.1.4-т “Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн санхүүгийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлнэ” гэж заалтыг хэрэгжүүлж хагас жилийн санхүүгийн тайланг 93 байгууллага, жилийн эцсийн санхүүгийн тайланг 99 байгууллага хуулийн хугацаандаа мэдээлсэн байна.

Хагас жилийн санхүүгийн тайланг 16 байгууллага, жилийн эцсийн тайланг 5 байгууллага хугацаандаа мэдээлээгүй ба 35 байгууллага хагас жилийн, 40 байгууллага жилийн эцсийн тайланг нэгдсэн цахим хуудсанд байршуулаагүй байна.

- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухай жилийн 04 дүгээр сарын 25-ны дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэдээлнэ” гэж заасны дагуу мэдээлэх ёстой 144 байгууллагаас 95 байгууллага буюу 66 хувь нь аудитын дүгнэлтийг, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг мэдээлэх ёстой 58 байгууллагаас 10 байгууллага буюу 17.2 хувь нь мэдээлсэн байна.

Харин аудитын дүгнэлтийг 3 байгууллага хугацаа хоцроож мэдээлж, 46 байгууллага буюу 32 хувь нь мэдээлээгүй, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 1 байгууллага хугацаа хоцроож мэдээлж, 47 байгууллага буюу 32.6 хувь нь мэдээлээгүй хуулийн 6.1.5 дах заалтыг зөрчсөн байна.

- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр мэдээлнэ” гэж заасны дагуу мэдээлэх ёстой 130 байгууллагаас 97 байгууллага буюу 74.6 хувь нь мэдээлж, 33 байгууллага буюу 25.4 хувь нь мэдээлээгүй байна.

Энэ нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна”, 6.3.3.-т “төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааны тайлбар” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн өмчийн “Суат” ХХК-ны шилэн дансны цахим хуудасны хаяг нь буруу нээгдсэнээс хуулийн 6.1.3-д заасан дараа жилийн төсвийн төсөл, 6.1.4-д заасан хагас жилийн санхүүгийн тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан, 6.1.5-д заасан аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг мэдээлэх цэсгүй, цахим хуудасны хаягийг шинээр нээлгэх талаар санаачлагагүй хандаж ирсэн бөгөөд түүнд хяналт тавих байгууллагууд ямар

нэгэн арга хэмжээ аваагүй байна. Иймээс энэхүү заалтыг шалгах боломжгүй байсан болно.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын дагуу тогтмол мэдээлэх мэдээллийг давхардсан тоогоор нийт 1181 байгууллагаас 780 байгууллага буюу 66 хувь мэдээлж байгаа нь хуулийн хэрэгжилт, түүнд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна. Хугацаа хоцорсон болон мэдээлээгүй байгууллагын дэлгэрэнгүй жагсаалтыг [тайлангийн хавсралт №01](#)-ээр харууллаа. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг нэгтгэж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №3

/сая.төгрөгөөр/

№	Долоо хоногийн дотор мэдээлэх мэдээлэлүүд	Мэдээлбэл зохих		Мэдээлсэн		Мэдээлээгүй		Хугацаа хоцорсон
		Гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Гүйлгээн ий тоо	Мөнгөн дүн	Гүйлгээн ий тоо	Мөнгөн дүн	
1	6.4.1. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	144	0	125		19		
2	6.4.2. Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	37	0	8		14		15
3	6.4.3. Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл	15	0			15		
4	6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл	208	3613.7	140	2887.3	68	726.4	
5	6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	1636	7129.8	1575	6390	61	739.8	
6	6.4.5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	2782	148424	2265	127619.8	517	20804.2	
7	6.4.6. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	0	0					
8	6.4.7. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	127	0	120		7		

9	6.4.8. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	35	223.6	35	223.6			
	Нийт дүн	4984	159391.1	4268	137120.7	701	22,270.4	15

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас авч нэгтгэсэн судалгаа

- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т заасан тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг мэдээлэх ёстой 144 байгууллагаас 125 байгууллага буюу 86.8 хувь нь мэдээлж 19 байгууллага нь мэдээлээгүй байна.

- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2 дах заалтын дагуу тухайн байгууллагын төлбөр хураамж зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг мэдээлэх ёстой 37 байгууллагаас 8 байгууллага хугацаандаа, 15 байгууллага хугацаа хоцроож мэдээлж, 14 байгууллага буюу 37.8 хувь нь мэдээлээгүй байна.

- Аймгийн 14 сум, 1 тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч нар тухайн жилийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын тендертэй холбоотой мэдээллийг мэдээлээгүй байгаа нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д “тендерийн баримт, бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг зөрчжээ.

- 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалттай холбоотой 208 удаагийн нийт 3613.7 сая төгрөгийн гүйлгээ гарснаас 68 гүйлгээний 726.4 сая төгрөгийн худалдан авалтын талаарх мэдээллийг 8 байгууллага мэдээлээгүй байгаа нь хуулийн 6.4.4 дэх заалтыг зөрчсөн байна.

- Аудитад хамрагдсан 147 байгууллагад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 2782 гүйлгээгээр 148424.0 сая төгрөгийн орлогын, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш зарлагын 1636 гүйлгээгээр 7129.8 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгджээ.

Үүнээс 49 байгууллага 517 гүйлгээний 20804.2 сая төгрөгийн орлогыг, 15 байгууллага 61 гүйлгээний 739.8 сая төгрөгийн цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байгаа нь хуулийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга хүлээн авагчийн нэрийг 7 хоногийн дотор мэдээлнэ”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2.2.1.13 дах заалтыг тус тус зөрчжээ.

- Хуулийн 6.4.6-д “худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг” мэдээлсэн байдлыг шалгахад ХАА-ны тайланд хяналт хийгдээгүй талаар тайлбар оруулжээ.

- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг мэдээлэх ёстой 127 байгууллагаас 120 байгууллага хуулийн хугацаанд мэдээлж, 7 байгууллага буюу 5.5 хувь нь мэдээлэлгүй хуулийн 6.4.7 дах заалтыг зөрчжээ.

- Хуулийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 7 хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг шалгахад аймгийн Засаг даргын хөрөнгө зарцуулах тухай 35 захирамжаар 223.6 сая төгрөгийн шийдвэр гарсныг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй, аймгийн www.bayan-ulgii.gov.mn сайтад байршуулж мэдээлсэн байна.

Сумуудын санхүүгийн алба нь Засаг даргын цэст Сум хөгжүүлэх сангийн мэдээллийг оруулах цэс байхгүй гэсэн шалтгаанаар Сум хөгжүүлэх сангаас шалгаруулсан төсөл, төсөлд олгосон зээлийн шийдвэр, олгосон зээл болон сангийн зээлийн авлагын талаарх мэдээллийг огт мэдээлээгүй хариуцлагагүй хандаж ирсэн байна.

2017 оны жилийн эцсээр 14 сумын 1240 иргэн, хуулийн этгээдэд олгосон 3980.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагыг мэдээлээгүй байгаа нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “...өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчжээ. Уг зөрчлийг аргилгуулахаар холбогдох албан тушаалтнуудад албан шаардлага хүргүүлэв.

Аудитад хамрагдсан бусад байгууллагууд төсөв, өмч хөрөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн талаарх аливаа шийдвэрийг мэдээлээгүй байгаа нь нийтлэг зөрчил байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”, 7.1.1-т “... холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан”, 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэж заасныг тус тус зөрчиж байгаа тул аудитын явцад зөвлөмж өгч ажилласан болно.

Долоо хоногийн дотор мэдээлэх мэдээллийн хуулийн хэрэгжилт нь 85.6 хувьтай байна.

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, их хэмжээний зөрчил гаргасан дараах байгууллагуудын холбогдох тушаалтнуудад зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

- *Аймгийн Шүүхийн тамгын газар тогтмол мэдээлэх ёстой 2 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг мэдээлээгүй, 726.5 сая төгрөгийн таван саяаас дээш 9 удаагийн орлогыг мэдээлээгүй.*

- *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба тогтмол мэдээлэх мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй, 359.6 сая төгрөгийн таван саяаас дээш 7 удаагийн орлогыг мэдээлээгүй.*
- *Зооносын өвчин судлалын төв нь тогтмол мэдээлэх 7 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг мэдээлээгүй. Мөн 198.8 сая төгрөгийн таван саяаас дээш 9 удаагийн орлогыг мэдээлээгүй.*
- *Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, 489.6 сая төгрөгийн таван саяаас дээш 13 удаагийн орлого, 5.8 сая төгрөгийн таван саяаас дээш зарлагыг мэдээлээгүй ба мэдээллийг хагас дутуу оруулсан.*
- *Нийгмийн халамжийн сан нь цахим хуудаст нээлгэсэн сангийн цэст мэдээллээ оруулаагүй, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын шилэн дансны цэст зөвхөн орлого, зарлагын мэдээллийг мэдээлж байсан байна.*
- *Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сан тогтмол мэдээлэх 10 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож, 3 мэдээллийг мэдээлээгүй, 962.5 сая төгрөгийн 13 удаагийн орлогыг цахим хуудасны цэст оруулаагүй.*
- *Аймгийн ИТХурал 394.9 сая төгрөгийн 5 удаагийн орлого, 104.4 сая төгрөгийн зарлагыг мэдээлээгүй.*
- *БОАЖГазар тогтмол мэдээлэх 8 мэдээллийг мэдээлээгүй, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.*
- *Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар 198.5 сая төгрөгийн 18 удаагийн орлого, 60.3 сая төгрөгийн таван саяаас дээш зарлагаа мэдээлээгүй.*
- *Сумдын төсөвт байгууллагаас нийт дүнгээр тогтмол мэдээлэх ёстой мэдээллээс 97 мэдээллийг хугацаа хоцроож, 332 мэдээллийг мэдээлээгүй байна. Мөн 17211.3 сая төгрөгийн 551 удаагийн орлого, зарлага, худалдан авалтыг, 3980.7 сая төгрөгийн Сум хөгжүүлэх сангийн 2017 оны зээл, зээлийн хүүгийн авлагыг шилэн дансны цахим цэст оруулаагүй зэрэг зөрчил илэрлээ.*


Уг зөрчлүүдийг арилгуулах арга хэмжээ авч ажиллах талаар аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан шаардлага хүргүүлэв.

А.2. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлсэн байна.


Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заасны дагуу аудитын явцад Баяннуур, Сагсай, Цэнгэл сумын төсөвт байгууллагууд болон аймгийн төвийн Өлгий сумын ЗДТГазар, ИТХурал, Нэгдсэн эмнэлэг, ХДТеатр, Цагдаагийн газар, Орон нутгийн Музей, Номын сан, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, БСУГазар, Прокурорын газар, Өлгий сумын 1, 2, 4, 6, 11, 12 дугаар Хүүхдийн цэцэрлэгүүд зэрэг байгууллагуудын мэдээллийн самбар ажиллуулж байгаа байдлыг түүвэрлэн шалгаж үзэхэд мэдээллийг бүрэн байршуулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллажээ.



Хөгжимт драмын театрын мэдээллийн самбар



Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэг, Өлгий сумын ЗДТГ-ын мэдээллийн самбар



Аймгийн нэгдсэн эмнэлгийн мэдээллийн самбар

Бүлэг

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Б. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна

Б.2 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах 3897.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59 тендерт шалгарсан 49 аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг олон нийтэд мэдээлээгүй зөрчил илэрсэн нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллага энэхуулийн үйлчлэлд хамаарна”, 6 дугаар зүйлийн 6.9-д “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, ЗГ-ын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, ОНХС-ийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагуудаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй” гэж заасан байна.

Аймгийн 2017 оны ОНХС-ийн хөрөнгөөр нийт 827.5 сая төгрөгийн өртөгтэй 33 төсөл арга хэмжээ хийгдэхээр аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга нар гүйцэтгэгч 20 хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, шилэн дансны цахим цэсдээ оруулжээ. 2017 оны сүүлийн улиралд гэрээ байгуулсан төсөл арга хэмжээнд 370.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд санхүүжилтийг өссөн дүнгээр нь мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллажээ.

2018 оны эхний 9 сарын байдлаар аймгийн ОНХСангийн хөрөнгөөр нийт 3906.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 ажил хийгдэхээр аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газар дарга нар гүйцэтгэгч 31 аж ахуйн нэгж, 1 төсвийн байгууллага, 1 иргэнтэй гэрээ байгуулж ажиллажээ.

Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Эн Эс Партнерс” ХХК-тай гэрээ байгуулсан Өлгий сумын 1-р БДС-ийн хуучин байрыг “Эх хүүхдийн хөгжлийн

төв” болгон өөрчлөн сэргээн засварлах ажлын 60.0 сая төгрөгийн, “Монхидро констракшн” ХХК-тай гэрээ байгуулсан Өлгий сумын үеийн хамгаалалтын барилга, байгууламжийн зураг төсвийн 150.0 сая төгрөгийн, нийт 210.0 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулаагүй байна.

2017 оны 4 дүгээр улиралд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 125.4 сая төгрөгийн 7 ажил, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 75.9 сая төгрөгийн 2 ажлын тендерт 6 аж ахуйн нэгж, 1 иргэн шалгарсан боловч гэрээ байгуулсан байгууллагууд талаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 оны эхний 9 сарын байдлаар нийт 1477.9 сая төгрөгийн 40 ажил, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2419.5 сая төгрөгийн 7 ажлыг хийж гүйцэтгүүлэхээр 51 аж ахуйн нэгж, 2 төсвийн байгууллага, 2 иргэнтэй гэрээ байгуулжээ.

Үүнийг санхүүжилт хүлээн авсан төсвийн байгууллагуудын шилэн дансны цэснээс шалгахад тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг мэдээлсэн байгууллага байхгүй байна. Харин www.bayan-ulgii.gov.mn сайтад 2975.8 сая төгрөгийн 23 ажлын тендерийг байршуулж зарласан байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах 3897.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59 тендерт шалгарсан 49 аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг олон нийтэд мэдээлээгүй зөрчил илэрсэн нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр тендер шалгаруулах болон ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулж мэдээлж байгаа эсэхэд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба тухай бүр хяналт тавьж ажиллах шаардлагатай байна

Б.3. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа хувийн 13 ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цэс нээлгээгүй, санхүүжилтийг бүрэн мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д “төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч энэ хуулийн үйлчлэлд хамаарна” гэж заасан байдаг.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтийг хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болох талаар тусгажээ.

2017 оны 4 дүгээр улирал болон 2018 оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд хувийн 6 ерөнхий боловсролын сургуульд нийтдээ 1275.4 сая төгрөгийн, 7 хүүхдийн цэцэрлэгт 170.8 сая төгрөгийн санхүүжилтийг тусгай зориулалтын

шилжүүлгээр олгосон боловч санхүүжилтийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна. Цэнгэл сумын “Руханят” бүрэн дунд сургуулиас бусад Өлгий сумын 12 хувийн сургууль, цэцэрлэгүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цэс нээлгээгүй байна.

Тус аймгийн Хүүхэд харах үйлчилгээний хоолны зардал болон хувьсах зардлын 308.2 сая төгрөгийн санхүүжилт нь Боловсрол, соёл, урлагийн газрын төрийн сан дахь 100020015401 тоот нэмэлт дансаар дамжиж аймгийн төвийн 23, сумын 50 иргэнд олгогдож байгаа бөгөөд үүнийг Боловсрол, соёл, урлагийн газар нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлэгдээгүй байна.

Цаашид төрийн ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч дээрх байгууллагуудад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгэж, олон нийтэд ил тод мэдээлэл хүргүүлэх ажилд хяналт тавьж ажиллахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд зөвлөмж болгов.

Бүлэг 3

Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байгаа боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

В. Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

В.1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд аймгийн ИТХ-аас хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

8.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн хурал,хэрэгжүүлнэ” гэж заасан боловч аймгийн ИТХ-ын ажлын албанаас ирүүлсэн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 1-02/464 тоот албан бичигт аймгийн ИТХ-аас 2018 онд Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн ямар нэгэн хяналтын ажил зохион байгуулаагүй байгааг дурдсан байна.

Сумдын ИТХ-аас шилэн дансны тухай хуулийн дагуу хөндлөнгийн хяналт хэрэгжүүлсэн эсэх талаар албан бичиг болон ажлын тайланг авч үзэхэд Цэнгэл, Сагсай, Улаанхус, Дэлүүн, Булган, Толбо, Буянт сумдын ИТХ-аас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьсан тухай тайлан ирүүлсэн байна.

Баяннуур сумын ИТХ-аас нэгдсэн цахим хуудас дахь тус сумын ОНХСан, сум хөгжүүлэх сангийн мэдээллийг байршуулах хэсэг эвдрэлтэй, мэдээлэл оруулж болохгүй байгаагаас холбогдох мэдээллийг байршуулж чадаагүй ба энэ талаар арга хэмжээ авч өгөх талаар холбогдох албан тушаалтанд танилцуулсан гэж албан бичигт дурдаад аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд хандсан 2018 оны 10 сарын 25-ны өдрийн 1/233 тоот албан бичгийг хавсаргаж ирүүлсэн байна.

Булган сумын ИТХ-аас сумын интернет сүлжээ тогтмол сайн ажилладаггүй байсантай холбоотой зөрчил дутагдал гарч байсан ба 11 дүгээр сараас шилэн кабелин сүлжээ нэвтэрсэн тул цаашид мэдээллийг тогтмол байршуулж ажиллах болно хэмээн тайланд дурдсан байна.

Буянт сумын ИТХ-аас Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай сумын Засаг даргад уламжилснаар 2018 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн №А/95 тоот захирамж гарган холбогдох албан тушаалтнуудад үүрэг даалгавар өгч биелэлтийг дахин шалгах аар ажлын хэсэг томилон ажиллаж байгаа, тус сумд хуулийн хэрэгжилт 70 хувьтай байна гэсэн мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт ирүүлжээ.

Сагсай сумын ИТХ-аас 5 хүний бүрэлдэхүүнтэй шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулан удирдамж батлуулан ажилласан байна. Удирдамжийн дагуу ажлын хэсэг сумын 6 төсөвт байгууллагын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийж гарсан зөрчлийг арилгуулах талаар холбогдох албан тушаалтнуудад үүрэг даалгавар өгч ажилласан байна.

Цэнгэл сумын ИТХ-аас тус хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлын удирдамж батлуулан, 2018 оны 10 дугаар сард 7 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилон шилэн дансны мэдээллийг шалгаж гарсан зөрчлийг арилган хуульд заасны дагуу хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан нь зохих үр дүнгээ өгсөн байна.

Алтай, Алтанцөгц, Өлгий сумдын ИТХ-аас Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийсэн ажлын тайлан, холбогдох материалыг ирүүлээгүй байна.

В.2. Шилэн дансны үйл ажиллагаанд Төсвийн ерөнхий захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ”, түүнчлэн Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 8.5-д “Төсвийн ерөнхийлөн захирагч /дотоод аудитын алба/ нь шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана” гэж заасны дагуу Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь шилэн дансны хуулийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дараах ажлуудыг зохион байгуулж ажиллажээ.Тухайлбал:

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг аж ахуйн нэгж байгууллага шилэн дансны нэгдсэн санд мэдээллээ нөхөж байршуулах талаар холбогдох албан тушаалтанд танилцуулж, Шилэн дансны тухай хуулийг ханган ажиллах талаар чиглэл өгч ажилласан байна.

- 2017, 2018 оны эхний 9 сарын байдлаарх Шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан тушаалтан болон сумдын санхүүгийн албаны дарга нарт шилэн дансны хуулийн хэрэгжилтийн явцыг цахим хуудаснаас шууд хянаж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар заавар зөвлөгөө өгч, энэ онд 2 албан бичиг хүргүүлжээ.

- 2017 оны 4 дүгээр улирал болон 2018 оны эхний 9 сарын байдлаар 94 төсвийн байгууллагын шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа шилэн дансны мэдээллийг хугацаанд байршуулж байгаа эсэхэд хяналт тавьж, зөвлөгөө өгч ажиллажээ.

- Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу “Улирал бүр тайлан илгээсэн эсэх” байдлыг хянах зааварчилгаа, ТЕЗ-ийн “аудитын эрх”-ийг бүх сумдын харьяа төсөвт байгууллагуудад цахимаар хүргүүлж, сумдын ТЕЗ-ийн Шилэн дансны хэрэгжилтийг ханган ажиллах талаар хамтран ажил зохион байгуулан шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг Сангийн яамнаас ирүүлсэн маягтын дагуу авч ажилласан байна.

- Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын байцаагч нар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалт хийх явцад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйгээр хангаж, зөвлөгөө өгч аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар арга хэмжээ авч ажиллажээ.

- 2018 оны эхний 9 сарын байдлаар Шилэн дансны нэгдсэн санд зохих мэдээллийг хугацаанд нь байршуулсан эсэхэд хяналт хийж, зөрчил гаргасан Баяннуур, Бугат, Булган, Буянт, Ногооннуур сумдын санхүүгийн албаны дарга нарт үүрэг өгч, илэрсэн зөрчлийг нэн даруй арилгаж, засаж залруулан хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар анхааруулан, сумдын төсвийн байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал, санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч нарт 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн №57 тоот албан бичиг хүргүүлсэн байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас заавар, зөвлөмж өгч, мэдээллээр ханган сумдын Засаг дарга, санхүүгийн албаны дарга нартай хамтран чиглэл өгч ажилласны үр дүнд Шилэн дансны нэгдсэн цахим хуудас дахь мэдээлэл байршуулалт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хуулийн хэрэгжилт сайжирсан боловч зарим төсвийн захирагч нар Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан журмын заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэл үнэн зөв, бодитой байх, иж бүрэн байх, мэдээлэл ойлгомжтой ач холбогдолтой байх, тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмыг баримталж, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллаагүй, зарим байгууллагууд өмнөх онд гаргасан зөрчил дутагдлуудыг давтан гаргасан байна.

Аймгийн Засаг дарга, ЗДТГ-аас 2017 онд төсөвт байгууллагуудын ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар ямар нэгэн заалт тусгагдаагүй байна.

Харин аймгийн Засаг даргын 2017 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн А/369 тоот захирамжаар “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам” батлагдаж, журмын 10, 11 дүгээр хавсралтаар баталсан “Байгууллагууд болон Сумын засаг дарга, Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт”-ийн 36, 39 дүгээр заалтад шилэн дансны мэдээллийг оруулсан байдал, авч хэрэгжүүлсэн ажлын талаар үнэлгээ хийх заалтыг оруулсан байна.

Энэхүү журмын дагуу 2017 оны сумдын ЗДТГ-ын үйл ажиллагааг дүгнэхдээ шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ гэсэн заалтыг оруулан 13 сум, 1 тосгоны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 10-90 оноогоор үнэлсэн байна.

Тус үнэлгээг Төрийн аудитын газраас 2017 онд хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитын дүнд үндэслэн дүгнэжээ.

Сангийн яамнаас 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дэлгэрэнгүй тайлан гаргасан байна.

Тус Тайлангаар хуулийн талаар товч мэдээлэл болон хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шилэн дансны хуулийн дагуу тавигдсан мэдээлэл, байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлт, Төсвийн ерөнхийлөн захирагчдын шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг нэгтгэн гаргажээ. Уг үнэлгээг 7 үзүүлэлтийн дунджаар дүгнэсэн бөгөөд Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 62,1% гэж үнэлэгдсэн байна.

Тус тайланд мэдээлэл тавих эрх бүхий албан тушаалтнуудыг нэгдсэн арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн байршуулахад анхаарч ажиллах, төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгжийн хяналтыг сайжруулж, хуулийг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, Хяналт шинжилгээ үнэлгээний нэгж, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын нэгжүүд болон дээд байгууллагаас хийгдэх аливаа хяналт шалгалт хийхдээ удирдамж болон тайланд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар бүлэг тусгаж байх шаардлагатай байна гэж дүгнэжээ.

В.3. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэлтэй иргэд олон нийт төдийлөн ач холбогдол өгч танилцаж, сонирхдоггүй байна.

Аудитын явцад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар судалгаа авсан. Тус судалгаанд нийт 100 иргэнийг хамруулсан ба хуулийн хэрэгжилттэй холбоотой 6 асуулгын хүрээнд иргэдийн санал бодлыг тусгасан. Судалгаанд хамрагдсан иргэдийн 61 хувь нь тодорхой ажил эрхэлдэг, 31 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй иргэд байна. Судалгааны дүнг нэгтгэж үзэхэд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болох shilendans.gov.mn сайтад зочилж мэдээлэл авч байсан уу? гэсэн асуултанд 43 хувь нь “тийм”, 57 хувь нь “үгүй”

- Та шилэн дансны тухай хууль болон түүний хэрэгжилтийн талаар хэр мэдээлэлтэй байна вэ? гэсэн асуултанд 36 хувь нь “сайн”, 43 хувь нь “дунд”, 21 хувь нь “огт мэдэхгүй”

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл ойлгомжтой байна уу? гэсэн асуултанд 35 хувь нь “тийм”, 54 хувь нь “үгүй”, 11 хувь нь энэ асуултад хариулаагүй байна.

- Тус хуульд заасан иргэний хяналтын талаар мэдэх үү? гэсэн асуултанд 39 хувь нь “тийм”, 61 хувь нь “үгүй”

- Та байгууллагуудын шилэн дансны мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллүүдтэй танилцдаг уу? гэсэн асуултанд 53 хувь нь “тийм”, 47 хувь нь “үгүй”

- Та хэрэгтэй мэдээллээ байгууллагуудын шилэн дансны мэдээллийн самбар болон нэгдсэн цахим хуудасны алинаас нь авдаг вэ? гэсэн асуултанд 15 хувь нь “шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас”, 23 хувь нь “байгууллагуудын мэдээллийн самбараас”, 10 хувь нь “шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон мэдээллийн самбарын аль алинаас нь”, 39 хувь нь “мэдээлэл авах шаардлага гардаггүй тул энэ талаар сонирхож байгаагүй”, 13 хувь нь “шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон мэдээллийн самбарын алинаас нь авч чаддаггүй” гэсэн хариултыг өгсөн байна.

Үүнээс гадна иргэд асуулгын хуудсанд “Байгууллагууд мэдээллийн самбарт ойлгогдохоор тодорхой мэдээллийг оруулж тогтмол хөтөлж байх”, “Мэдээллийн самбар болон цахим хуудаст мэдээллийг цаг хугацаанд нь шинэчлэн оруулж байх”, “Шилэн дансны тухай хуулийн талаар иргэдийг мэдээллээр хангаж мэдлэгтэй болгох талаар анхаарах хэрэгтэй”, “Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг тогтмол мэдээлж байх хэрэгтэй” гэсэн санал хүсэлтүүдийг дурдсан байна.

Дээрх санал асуулгаас дүгнэж үзэхэд иргэд Шилэн дансны тухай хуулийн талаар мэдлэг, мэдээлэл хангалттай бус, иргэний хувьд тавих хяналтын талаар ойлголт дутмаг, шилэн дансны цахим хуудсыг төдийлөн сонирхдоггүй байна. Шаардлагатай тохиолдолд шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас илүүтэй байгууллагын мэдээллийн самбараас мэдээлэл авч танилцдаг байна.

Тайлант хугацаанд иргэдээс шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явц, шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдалтай холбоотой аймаг дахь Төрийн аудитын газарт өргөдөл, гомдол ирүүлсэн асуудал гаргаагүй байна.

В.4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоодын хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцоогүй байна.

Аймгийн аудитын газраас 2017 оны 11 дүгээр сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгээр аймгийн Засаг даргад Шилэн дансны тухай хууль, тогтоомжийг хангалтгүй хэрэгжүүлсэн орон нутгийн төсвийн харьяа 49 байгууллагад 17356.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 01/56 тоот албан шаардлага, зөрчлийг давтан гаргаж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, 33875,0 сая төгрөгийн зөрчил гаргасан 23 албан тушаалтанд сахилгын шийтгэл ноогдуулах тухай 02/57 тоот албан шаардлага, улсын төсвийн 27 байгууллагад 26455,1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах тухай 27 албан шаардлага өгөгдсөнийг биелэлтийг тус тус шалгаж үзэхэд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан нэр бүхий 23 албан тушаалтанд сахилгын шийтгэл ноогдуулах тухай аймгийн Засаг даргад Төрийн аудитын газраас хүргүүлсэн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02/57 тоот албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Аймгийн Засаг дарга 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/746 дугаар захирамж гаргасан ба захирамжийн 1-д “...албан шаардлагын 1, 2 дугаар хавсралтад нэр заагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад шилэн дансны

нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих мэдээллээ хуулийн хугацаанд үнэн зөв байршуулж, зөрчлийг арилгаж ажиллахыг анхааруулсугай” гэж заасан нь Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалттай нийцээгүй бөгөөд албан шаардлагын дагуу зөрчил гаргасан албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулаагүй өнгөрөөсөн байна.

2. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлсэн орон нутгийн төсвийн харьяа 49 байгууллагад зөрчлийг арилгуулах талаар аймгийн Засаг даргад Төрийн аудитын газраас 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01/56 тоот албан шаардлагын дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Албан шаардлагын дагуу аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/746 тоот захирамж гаргаж, Засаг даргын эрх хэмжээний хүрээнд захирамжид нэр заагдсан аймгийн төвийн 9 байгууллага, сумдын нийт 86 төсвийн байгууллагад хуулийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийг арилгах, шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг тогтмол хийж байхыг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд үүрэг болгосон.

- Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дээрх 86 төсвийн байгууллагын шууд захирагч нар болон сумдын ИТХ, Засаг дарга нарт 2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн №10, 11 тоот албан бичгүүдээр шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь үнэн зөв бүрэн байршуулж ажиллах, хуулийн хэрэгжилтэд шат шатны хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг анхааруулж аймгийн Төрийн аудитын газрын албан шаардлага, аймгийн Засаг даргын захирамжийг хавсарган хүргүүлжээ.

Тус албанаас 2018 оны эхний 9 сарын байдлаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдалд хяналт шалгалт хийж, зөрчил гаргасан төсөвт байгууллагын нягтлан бодогч, санхүүгийн албаны дарга, төсвийн шууд захирагч нарт 2018 оны 10 дугаар сарын 08-ны 57 тоот албан бичгийг хүргүүлсэн байна.

3. Улсын төсвийн 27 байгууллагад зөрчлийг арилгуулахаар өгсөн албан шаардлагуудын хувьд тухайн үед холбогдох албан тушаалтнуудаар зөрчлийг арилгуулан шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг нөхөж байршуулан биелэлтийг хангуулан баримтжуулан ажилласан.

Дээрх мэдээллээс дүгнэн үзэхэд өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагын дагуу шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж зөрчлийг арилгуулж ажилласан боловч хариуцлага тооцуулах албан шаардлагын биелэлтийг хангаж ажиллаагүй байна.

Аудитын дүнгээр нийт 4 зөвлөмж, 76 байгууллагын 30267.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар Санхүүгийн хяналт, аудитын албанд албан шаардлага, давтан болон их зөрчил гаргасан нийт 47 байгууллагын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах саналыг тус тус хүргүүлэв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, нийцлийн аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

А. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдсан боловч зарим байгууллагууд мэдээллийг бүрэн оруулаагүй байна.

А.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тогтмол мэдээлэх мэдээллийг 34 хувь нь, долоо хоногийн дотор мэдээлэх мэдээллийг 14.4 хувь нь мэдээлээгүй байна.

А.2. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлсэн байна.

Б. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Б.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах 3897.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59 тендерт шалгарсан 49 аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг олон нийтэд мэдээлээгүй зөрчил илэрсэн нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Б.3 Төрийн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа хувийн 13 ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цэс нээлгээгүй, санхүүжилтийг бүрэн мэдээлээгүй байна.

В. Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

В.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд аймгийн ИТХ-аас хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

В.2 Шилэн дансны үйл ажиллагаанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

В.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэлтэй иргэд олон нийт төдийлөн ач холбогдол өгч танилцаж, сонирхдоггүй байна.

В.4 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын дагуу шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоодын хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцоогүй байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Х.Ербол-д:

1. Өмнөх аудитаар илэрсэн зөрчил давтагдан гарсан байдалд дүгнэлт хийж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллах, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах.
2. Аймгийн Засаг даргын шилэн дансны цэст улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний тендер шалгаруулалт, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг нөхөж оруулах, цаашид хяналт тавьж ажиллах.
3. Төрийн ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч дээрх байгууллагуудад нэгдсэн цахим хаяг нээлгэж, олон нийтэд ил тод мэдээлэл хүргүүлэх ажилд хяналт тавьж ажиллах.
4. Орон нутгийн өмчийн “Суат” ХХК-ны шилэн дансны цэс нь буруу нээгдсэнээс мэдээллийг бүрэн оруулах боломжгүй байгаа асуудлыг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст шинээр цэс нээлгэж шийдвэрлүүлэх, хяналт тавьж ажиллах.

Тайлангийн хавсралт №01

Хуулийн хэрэгжилт хангаж ажиллаагүй байгууллагуудын жагсаалт




№	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих мэдээ болон хугацаа хоцроосон байдал				
		6.1 Тогтмол мэдээлэх		6.4 Долооо хоног бүр мэдээлэх		
		Мэдээлээгүй	хугацаа хоцорч мэдээлсэн	Мэдээлээгүй		
				5.0 сая төгрөгөөр дээш үнийн дүнтэй орлого, зарлага, ХАА-ын гүйлгээний тоо	мөнгөн дүн /сая төг/	СХСангийн зээлийн авлагын дүн /сая төг/
1	Аймгийн Шүүхийн тамгын газар	5	2	10	726.5	
2	Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	2	5	9	359.6	
3	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар		2	12	804.2	
4	Аймгийн Зоонозын өвчин судлалын төв	8	7	9	198.8	
5	Дэлүүн Сум дундын эмнэлэг	2		12	539.3	
6	Боловсрол, соёл урлагийн газар	1		9	308.2	
7	Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	7	6	13	495.4	
8	Нийгмийн халамжийн сан	19	1	1		
9	Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	10	6	962.5	
10	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	4	1	25	499.3	
11	Аймгийн Засаг дарга	7		61	3,897.4	
12	Орон нутгийн өмчийн газар	-	3	4	25.4	
13	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	8	4			
14	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	18		15	258.8	
15	Алтай сумын Засаг дарга		1	1		239.6
16	Алтай сумын ЗДТГазар	15	3	13	240.9	
17	Алтай сумын Улаанхад бага сургууль	3	3	15	115.0	
18	Алтанцөгц сумын Засаг дарга	3		5	48.0	195.0
19	Баяннуур сумын Засаг дарга	7		11	61.0	343.0
20	Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэг	5	2	7	241.9	

21	Баяннуур сумын Цагаан арал бага сургууль		3	11	174.5	
22	Бугат сумын Засаг дарга	6	1	6	33.7	203.9
23	Бугат сумын ЗДТГазар		8	7		
24	Бугат сумын ЕБСургууль	9	3	1	7.7	
25	Булган сумын Засаг дарга	7		16	228.5	227.2
26	Булган сумын ЗДТГазар	19	1	13	339.9	
27	Булган сумын Ёлт бага сургууль	9	2	13	186.3	
28	Булган сумын Хүүхдийн цэцэрлэг	21		13	226.2	
29	Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэг	15	2	13	90.4	
30	Булган сумын Эрүүл мэндийн төв	13	2	13	408.1	
31	Буянт сумын Засаг дарга	5		2		130.4
32	Буянт сумын ЗДТГазар	8	4	1		
33	Буянт сумын ЕБСургууль	3		2	20.2	
34	Дэлүүн сумын Засаг дарга	2		1		273.9
35	Дэлүүн сумын ЕБСургууль	7	3	12	2,010.9	
36	Дэлүүн сумын Хүүхдийн цэцэрлэг	8		12	398.2	
37	Ногооннуур сумын Засаг дарга	4		14	78.5	257.2
38	Ногооннуур сумын ЕБСургууль	5		2	24.3	
39	Сагсай сумын Засаг дарга					243.1
40	Сагсай сумын ЗДТГазар	3		13	284.5	
41	Сагсай сумын ЕБСургууль	20		19	1,365.7	
42	Сагсай сумын Даян бага сургууль	10	4	13	133.9	
43	Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэг	14	1	10	197.3	
44	Сагсай сумын Эрүүл мэндийн төв	12		12	382.5	
45	Улаанхус сумын Засаг дарга	3		1		388.1
46	Улаанхус сумын ЗДТГазар	1	1	9	263.4	
47	Улаанхус сумын ЕБСургууль	1	1	10	1,362.3	
48	Улаанхус сумын Согог дунд сургууль	1	1	9	567.7	
49	Улаанхус сумын Согог цэцэрлэг		1	5	80.4	

50	Улаанхус сумын Хөххөтөл цэцэрлэг		1	5	83.6	
51	Толбо сумын Засаг дарга			1	24.5	224.9
52	Толбо сумын ЗДТГазар	2	1	13	372.3	
53	Толбо сумын ЕБСургууль	3	3	17	1,311.2	
54	Толбо сумын Хүүхдийн цэцэрлэг	6	4	12	244.8	
55	Толбо сумын Эрүүл мэндийн төв	4	4	12	330.0	
56	Цагааннуур тосгоны захирагч					1.5
57	Цагааннуур тосгоны захирагчийн алба	4	2	9	109.7	
58	Цагааннуур тосгоны Дунд сургууль	1		9	279.1	
59	Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэг			9	139.4	
60	Цагааннур тосгоны Эрүүл мэндийн төв	2	1	12	180.3	
61	Цэнгэл сумын Засаг дарга	2		1		287.7
62	Өлгий сумын Засаг дарга	6		18	173.1	965.2
63	Өлгий сумын ЕБ-ын 1-р сургууль			4	64.6	
64	Өлгий сумын ЕБ-ын 4-р сургууль	7	8			
65	Өлгий сумын ЕБ-ын 5-р сургууль			18	1,912.8	
66	Өлгий сумын ЕБ-ын 6-р сургууль			8	437.3	
67	Өлгий сумын 1-р бага сургууль		8	4	45.1	
68	Өлгий сумын "Эрдэм" бага сургууль	5		9	297.7	
69	Өлгий сумын Хотгор бага сургууль	20		13	121.9	
70	Өлгий сумын 3-р хүүхдийн цэцэрлэг			11	274.7	
71	Өлгий сумын 5-р хүүхдийн цэцэрлэг	6		12	366.1	
72	Өлгий сумын 6-р хүүхдийн цэцэрлэг			13	375.9	
73	Өлгий сумын 7-р хүүхдийн цэцэрлэг	5	8	12	260.0	
74	Өлгий сумын "Эрдэм" хүүхдийн цэцэрлэг	2		12	72.7	
75	Өлгий сумын 13-р хүүхдийн цэцэрлэг	15				
76	Өлгий сумын 16-р хүүхдийн цэцэрлэг	3	10	12	162.6	
	Нийт дүн	416	138	737	26,286.7	3,980.7
	Бүгд дүн			1,291		30,267.4

Холбогдох байгууллагын санал

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас ирүүлсэн санал:

 САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА 83129 Өмнө, Баян-Өлгий аймаг, Уластбайс (976) 7042-3401	БЯАН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ
2018.11.30 № 21 тантай _____ -ны № _____ -т	
Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн тухай	
<p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2017 оны 10 дугаар сараас 2018 оны 10 дугаар сар хүртэлхи хугацаанд хийгдсэн нийцлийн аудитын тайлантай танилцаж үзлээ.</p> <p>Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ - гэж заасан ба 69.3-д дотоод аудитад Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна - гэж заасан байдаг тул бид Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шилэн дансны хэрэгжилтийн хяналтыг хариуцан ажиллаж ирсэн болно.</p> <p>Өнгөрсөн оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн аудитаар 133 байгууллагад 51 367,3 сая төгрөгний зөрчил илэрч байсан бол энэ жилийн нийцлийн аудитаар 76 байгууллагад 30 267,4 сая төгрөгний зөрчил илэрч, өнгөрсөн оноос 57 байгууллагын тоо цөөрч, зөрчлийн мөнгөн дүн 21 099,9 мянган төгрөгөөр буюу 41.1%-иар буурсан үзүүлэлттэй гарсан байна. Хэдий буурсан үзүүлэлттэй гарсан боловч шилэн дансны хуулийн хэрэгжилт бүрэн гүйцэт хэрэгжихгүй байгаа юм байна. Иймд дараагийн жилд манай албаны зүгээс тавих дотоод хяналтыг улам чангатгаж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй хуулийн этгээдээс хариуцлага тооцуулан ажиллах болно.</p> <p>Уг тайлан нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хүрээнд үнэн зөв, бүрэн хийгдсэн байна.</p> <p>Харинцан мэдээлэл солилцож, хамтран ажилласан танай хамт олонд талархал илэрхийлье.</p>	
 ДАРГА  Р. ХУАТХАН	

ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М. ХУАНГАН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ж.НАЗГҮЛ

АУДИТОР

Р.БАЯРМАА